



СҮХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

7 давхарт, DG TOWER, Балдан-Осорын гудамж, 7-р баг
Баруун-Урт сум, 22075
Утас: 70518892 Факс: 70518892
Цахим шуудан: baigalorchin@sukhbaatar.gov.mn
Цахим хуудас: www.baigalorchin.su.gov.mn

2024.08.22 № 221

танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

БОАЖСайдын 2018 оны А/194 дүгээр тушаалаар батлагдсан “Монгол Улсын нутагт идлэг шонхор шувуу барих, тээвэрлэх, арчлах, гадаад улсад гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам”- ыг баримтална.

Уг журмын 8 дугаар зүйлийн 8.5-д “Барьсан шонхорыг буцаан тавихдаа биеийн аль нэг хэсэгт, тэмдэглэх, имлэх, өд далавч, бусад эрхтнийг гэмтээхийг хатуу хориглоно.”

8 дугаар зүйлийн 8.6-д “тухайн сумын ЗДТГ-аас орон нутгийн төлөөлөгч хүнийг томилон идлэг шонхор барих хугацаанд байнга ажиллуулна.”


8 дугаар зүйлийн 8.8-д “буцааж тавьсан идлэг шонхор шувуу бүрт бүртгэл хөтөлнө”, мөн идлэг шонхор шувуу барих, зөөвөрлөх, тээвэрлэх, арчлах, суллан тавихдаа идлэг шонхор шувуу гэмтсэн, үхсэн тохиолдолд үхсэн идлэг шонхор шувуунд хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр төлүүлэх, гэмтсэн идлэг шонхор шувууг арчлах, эмчлэх бүх зардлыг гадаад улсад гаргагч хариуцна” гэж заасныг тус тус үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана уу.

Идлэг шонхор барих отог нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг холбогдох байгууллагаар хийлгүүлэх шаардлагатай.

Буудалласан газраа цэвэрлэх, сумын ЗДТГ-тай хог хаягдлын гэрээ байгуулах, хүрээлэн буй орчин бохирдуулахгүй байх, явахдаа хүлээлгэж өгөх зэрэг болно.

Идлэг шонхор шувуу барих отогт өгөх зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна. Зөвлөмжийг танилцуулж, гарын үсэг зуруулан хяналт тавьж ажиллана уу.

Зөвлөмжийн талаарх хийсэн ажлын тайланг сар бүр ирүүлнэ үү.



Сүхбаатар аймгийн байгаль орчин, аялал
жуулчлалын газар
Захиргаа
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Шархүү Нямхүү
2024-08-22 08:13:24